



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/878

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум дунд, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бага насны хүүхдийн амьсгалын замын эмгэгийг эмчлэхэд нэн шаардлагатай утлагын аппарат олгоход 4700 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 4700 000 төгрөг /дөрвөн сая долоон зуун мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын "Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Уранчимэг-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/878 Ch

02. 04245

Аймгийн Засаг даргын 2019 оны 12  
дугаар сарын 20-ны өдрийн А/878  
дугаар захирамжийн хавсралт



БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛОН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ,  
СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН  
АМЬСГАЛЫН ЗАМЫН ЭМГЭГИЙГ ЭМЧЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ УТЛАГЫН  
АППАРАТ ОЛГОХ ЗАРДЛЫН ТООЦОО

| №        | Зардлын товч утга | Тоо ширхэг | Нэг бүрийн<br>үнэ /мян төг/ | Нийт үнэ<br>/мян төг/ |
|----------|-------------------|------------|-----------------------------|-----------------------|
| 1        | Утлагын аппарат   | 25         | 190.000                     | 4750 000              |
| НИЙТ ДҮН |                   |            |                             | 4750 000              |